



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/364

Булган сум

“Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших” уриалгад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллагуудаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу үндэсний бахархал болсон өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулах зорилгоор “Монгол үндэсний дээл, хувцастай өдөр”-ийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүрийн эхний долоо хоногийн Даваа гарагт байхаар өөрчилсүгэй.

2.Тус өдөр үндэсний дээл, хувцсаа өмсөж, хэвшүүлэхийг бүх шатны байгууллагуудын дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт уриалсугай.

3.Дээрх уриалгыг аж ахуйн нэгж, албан байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (Г.Алдармөнх)-т даалгасугай.

4.Энэхүү уриалга нь төрийн тусгай албаны алба хаагчдад хамаарахгүй болохыг дурдсугай.

5.Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/145 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

